

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Дотоод аудит, хяналт шалгалт 2019, 2020, 2021 оны 3-р улирал

Хамрагдсан байгууллага: Нийслэлийн Мэдээллийн технологийн газар

Улаанбаатар хот
2021 он

А/987 - Оюлдийн
бүчсэг төв.

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА.....	4
ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	4
Зорилго	4
Хамрах хүрээ	5
Өмнөх шалгалтаар	5
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН	5
Стратеги төлөвлөгөө:	6
Ёс зүйн зөвлөлийн талаар:	7
Тушаал шийдвэрийн талаар:	7
Санхүүгийн үйл ажиллагааны талаар:	7
Мөнгөн хөрөнгө:	8
Авлага:	8
Урьдчилж гарсан зардал:	8
Бараа материал:	9
Өглөг:	10
Төсвийн гүйцэтгэл:	12
Хөрөнгө оруулалт:	14
ДҮГНЭЛТ	17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЗД	Нийслэлийн Засаг дарга
ДАГ	Дотоод аудитын газар
НМТГ	Нийслэлийн Мэдээлэл технологийн газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НӨАУГ	Нийслэлийн Өмчийн ашиглалат, удирдлагын газар
ОНХС	Орон нутгын хөгжлийн сан
ЧД	Чингэлтэй дүүрэг
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүний нөөцийн хөдөлгөөн

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлан 2019 он, 2020 он, 2021 оны 3-р улирал

Хүснэгт 3. Дансны авлага

Хүснэгт 4. Бараа материалийн үлдэгдэл

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгөрүү шилжүүлэх хөрөнгө

Хүснэгт 6. Данс бүртгэлээс хасах

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгө

Хүснэгт 8. Өглөг

Хүснэгт 9. Нэмэлт санхүүжилт

Хүснэгт 10. Төсвийн зарцуулалт

Хүснэгт 11 Мэдээллийн технологийн үйлчилгээгийн зардал

Хүснэгт 12 Хөрөнгө оруулалт


Хүснэгт 13 Ажлын гүйцэтгэлийн үлдэгдэлийг барьцаа дансанд төвлөрүүлсэн

Хүснэгт 14 Гүйцэтгэлийн алданги

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Засаг дарга (НЗД)-ын 2005 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 22 дугаар захирамжаар анх нийслэлийн Мэдээллийн технологийн газар (НМТГ)-ыг гурван хэлтэстэй 15 хүртэл албан хаагчтайгаар анх байгуулсан. НЗД-ын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/241 дүгээр захирамжаар НМТГ-ын бүтэц орон тэог шинэчлэн 31 хүртэл албан хаагчтай гурван хэлтэстэйгээр ажиллаж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



НЗД-ын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/311 дүгээр захирамжаар Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дүрмийг баталсан. НМТГ нь Засгийн газрын болон НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, төрөөс харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, нийслэлийн төр захиргааны байгууллагуудын үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг мөн гэж заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь 9167269 улсын бүртгэлийн дугаартай, Төрийн сан банканд 4, Улаанбаатар хотын банканд 1 нийт 5 харилцах данстай.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг тус газрын дарга О.Чинзориг, хоёрдугаар гарын үсгийг 2020 оны 02 дугаар сарын 17 хүртэл ННҮГ-ын нягтлан бодогч Б.Бэхжаргал, 2020 оны 5 дугаар сарын 31 хүртэл Л.Төгөлдөр мөн өдрөөс ННҮГ-ын нягтлан бодогч Б.Байгальмаа нар тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Төсвийн тухай хуулийн 69.3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлэх тухай” 483 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 12 дугаар удирдамжийн дагуу Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор Д.Нансалмаа, дотоод аудитор Г.Хулан нар аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

Зорилго

Байгууллагын үйл ажиллагаа төсөв, санхүү өмч хөрөнгөтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай хэр нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

Хамрах хүрээ

Дотоод аудитад тус байгууллагын 2019 он, 2020 он, 2021 оны гуравдугаар улирлын үйл ажиллагаа, НМТГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хамруулж, аудитын зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болголоо. Үүнд:

- НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуулиуд, байгууллагад мөрдөх заавар журам, тогтоол, шийдвэрүүд;
- НЗД-ын 2019 оны А/311 дугаар захирамжаар батлагдсан дүрэм;
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал;
- УСНББОУС;
- Бусад.

Аудитыг үндсэн үйл ажиллагаа, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцыг үнэлэх, санхүүгийн тайлангууд, журнал, анхан шатны баримтуудыг хамруулан явуулж, тооцооллыг давтан шалгаж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг аудитын горимын дагуу нотлох баримт цуглуван гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Өмнөх шалгалтаар

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын 2019, 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материяллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох жураамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

Тус газар нь дүрмээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр Үүнд:

2020 онд Азийн сангаас хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд нийслэлийн цахим үйлчилгээний <https://eservice.uulaanbaatar.mn/> системд шинээр цахимжуулах боломжтой 20 үйлчилгээг цахимжуулах, иргэд олон нийтэд суртчилан таниулах, Иргэдийн оролцоотой газрын зураглалын систем болох <https://manaikhoroos.mn/>-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, стратеги төлөвлөгөөний дагуу хөгжүүлэлт хийгдэж, хэрэгжилтийг хангаж байна.

Улаанбаатар хотын авто машин, гудамж талбайд RFID системийн төсөл

2020 онд Улаанбаатар хотын төвийн 8 уулзвар, Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 7 товчоодод стандартын шаардлага хангасан /RFID/ таг үншигч тоног төхөөрөмжийг суурилуулсан. RFID төхөөрөмж суурилуулсан 8 уулзварын байршил нь: 103-ын арын уулзвар, Хөгжим бүжгийн уулзвар, 5-р сургуулийн урд уулзвар, Хүүхдийн ордны уулзвар, Контенталын уулзвар, Цэцэг төвийн уулзвар, 4-р дэлгүүрийн уулзвар, Хүнсний 1-ийн уулзваруудад суурилуулсан.

RFID төхөөрөмжид суурилсан замын хөдөлгөөний системийг нэвтрүүлснээр:

- Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй бүх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дугаарын хязгаарлалт, татвар төлөлт, даатгалд хамрагдсан байдал зэрэг автоматаар хяналт тавина.
- Замын хөдөлгөөний зөрчлийн торгууль, замын болон автомашины татвар хураалтыг нэмэгдүүлнэ.

- Зөрчилтэй тээврийн хэрэгслийг шуурхай илрүүлж, арга хэмжээ тооцох боломж бүрдэнэ.
- Банктай хамтран ажиллаж торгуулийг банк дээр авлага үүсэх байдлаар зохион байгуулж, үүссэн торгуулийг хурдан шуурхай шийдвэрлэх боломжтой болно.
- Улаанбаатар хотын авто замын урсгалд бэдит хяналтыг тавьж, замын ачаалал болон төлөвлөлтөд зохицуулалт хийх боломжийг олгоно.

“Нэг тархи нэгдсэн систем” төсөл

Нийслэл дэх цахим шилжилтийн хүрээнд “ НЭГ ТАРХИ НЭГДСЭН СИСТЕМ ”-ийн төслийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ. “ НЭГ ТАРХИ НЭГДСЭН СИСТЕМ ”-ийн төсөл нь дараах 3 дэд төслийн нэгдсэн системийн төслийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

- **Цахим засаглал /Digital Governance/:** Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, албан хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид түргэн шуурхай, ил тод байдлаар хүргэх боломжийг бүрдүүлсэн, хялбар, ойлгомжтой төрийн үйл ажиллаганы соёлтой орчинг бий болгох ухаалаг хотын цогц шийдлүүдийг нэвтрүүлэх;
- **Зам тээврийн нэгдсэн ухаалаг систем: /Smart Transportation/:** Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн хяналтыг нэмэгдүүлэх, автомат хяналтад оруулах, тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах цогц шийдэл нэвтрүүлэх;
- **Аюулгүй хот /Safe City/:** Нийслэл хотын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулан ажиллах зорилгоор Улаанбаатар хотын гудамж, зам, талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухаалаг хяналт удирдлагын цогц шийдэл нэвтрүүлэх юм.

Газрын дарга 2021 онд НЗД-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 16, хуулиар тусгайллан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 20, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 11, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх 4, нийт 51 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг тайлagnаж байна.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөг батлуулан ажилласан байна.

Стратеги төлөвлөгөө:

НМТГ нь дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна. Энэ нь ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжилтийг хангах журам”-тай нийцэхгүй байна.

Даргын зөвлөлийн талаар:

НМТГ-н 2020 оны даргын зөвлөл 10 удаа, 2021 онд даргын зөвлөл 4 удаа хуралдаж, цаг үеийн шинжтэй асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэжээ. Зөвлөлийн хурлаас гарсан үүрэг, даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлж ажилласан байна.

Хүний нөөц, оновчтой хуваарилалтын талаар:

НЗД-ын 2019 оны А/341 дүгээр захирамжийг үндэслэн тус газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын байрны жагсаалтыг 31 албан хаагчтай байхаар баталсан байна. 2020 оны эхэнд 29, эцэст 25 албан хаагч, 2021 оны гурав дугаар улиралд 27 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан ба хүний нөөцийн хөдөлгөөнийг харуулбал:

Хүснэгт 1

Хүний нөөцийн хөдөлгөөн

№	Үзүүлэлт	2019	2020	2021 оны гуравдугаар улирал
1	Ажлаас чөлөөлөгдсөн /өөрийн хүсэлтээр/	5	11	3
2	Шилжин явсан		1	
3	Жирэмсний амралт	1	1	1
4	Томилогдсон албан хаагч	12	11	11

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар:

Тус байгууллагад дотоод хяналт хариуцсан мэргэжилтэнгүй ба хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн жил бүр бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг тайлagnаж ажилладаг байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ үнэлгээний удирдамжийг жил бүр батлуулан ажилладаг боловч байгууллагын эрсдлийг тооцож ажилладаггүй, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэнгийн ажлын байрны тодорхойлолтод дотоод хяналт шалгалт хийх чиг үүргийг тусгаагүй байна.

Ёс зүйн зөвлөлийн талаар:

Газрын даргын 2019 оны А/06 дугаар тушаалаар ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу хамт олны хурал хийж ёс зүйн зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус газар нь 2019 онд даргын А тушаал 59, Б тушаал 41 нийт 100. 2020 онд А тушаал 71, Б тушаал 52, нийт 123, 2021 оны гурав дугаар улирлын байдлаар А тушаал 25, Б тушаал 31 нийт 56 тушаалыг гаргасан бөгөөд тушаалуудын үндэслэлийг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд нийцүүлсэн боловч МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын “2.2. түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.” заалт, МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

НМТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайландаа 2,421 806.8 мянган төгрөгийн эргэлтийн, 4,799,233.4 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 7,221 040.3 мянган төгрөгийн хөрөнгө тайлagnасан байна.

Нийт хөрөнгийн 33.5 хувийг эргэлтийн хөрөнгө, 66.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр ба эздийн өмчийн 97.4 хувийг эздийн өмч, 2.6 хувийг өр төлбөр эзэлж байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлан 2019 он, 2020 он, 2021 оны 3-р улирал /мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	2018.12.31	2019.12.31	2020.12.31	2021.09.30
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,458,369.8	2,421,806.8	2,326,106.2	2,543,814.5
Мөнгөн хөрөнгө	271,171.9	181,354.2	245,489.0	447,405.7
Авлага	748.8	748.8	748.8	748.8
Урьдчилгаа	55,701.5	55,701.5	55,701.5	65,151.5
Бараа материал	2,130,747.6	2,184,002.4	2,024,166.9	2,030,508.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,728,593.9	4,799,233.4	3,742,164.4	2,416,409.6

Биет хөрөнгө	1,456,005.2	1,343,801.7	1,567,508.3	1,171,363.3
Биет бус хөрөнгө	4,272,588.6	3,455,431.7	2,174,656.2	1,245,046.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,186,963.7	7,221,040.3	6,068,270.6	4,960,224.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	274,265.4	184,447.7	248,582.5	140,067.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	274,265.4	184,447.7	248,582.5	140,067.9
Ажилчидтай холбогдсон өглөг	21.2	21.2	21.2	21.2
Байгууллагад төлөх өглөг	274,244.2	184,426.5	248,561.3	140,046.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,912,698.3	7,036,592.6	5,819,688.1	4,820,156.1
Засгийн газрын хувь оролцоо	7,912,698.3	7,036,592.6	5,819,688.1	4,820,156.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	347,242.0	347,242.0	347,242.0	347,242.0
Хуримтлагдсан үр дүн	7,559,082.3	6,682,976.6	5,466,072.2	4,466,540.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,374.0	6,374.0	6,374.0	6,374.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,186,963.7	7,221,040.3	6,068,270.6	4,960,224.0

НМТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгө 1,057,069.0 мянган төгрөгөөр буурсан нь тус онд үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Тайлант онд санхүүгийн байдлын тайландаа 2,543,814.5 мянган төгрөгийн эргэлтийн, 2,416,409.6 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 4,960,224.0 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Мөнгөн хөрөнгө:

Мөнгөн хөрөнгийн данс нь Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барьцаа дансны үлдэгдэл 2019 онд 14 ажлын 181,354.2 мянган төгрөг, 2020 онд 21 ажлын 245,489.0 мянган төгрөг, 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 16 ажлын 134,576.2 мянган төгрөг, 2021 оны урсгал санхүүжилтийн үлдэгдэл 310,386.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 44.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

Авлага:

Хувь хүнээс авах 183,3 мянган төгрөг, ЧД-н НДХ-ээс авах 565,5 мянган төгрөг, нийт 748,8 мянган төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 2017 оны авлага байна.

Хүснэгт 3

Дансны авлага

/Мянган төгрөгөөр/

№	Нэр	2019-2021 оны 3-р улирал		Насжилт 3-4 жил
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	Балдандорж	15.0	15.0	15.0
2	Мөнхжаргал	168.3	168.3	168.3
3	ЧД-н НДХэлтэс	565.5	565.5	565.5
Нийт дүн		748.8	748.8	748.8

Урьдчилж гарсан зардал:

Тус дансанд 2012 онд Эмээлт, Баруун турууны шалган бүртгэх автомат хаалт болон хяналтын системийн угсралт, суурилуулалтын зар сурталчилгаа болон үүнтэй холбогдон гарсан бусад үйлчилгээний зардал болох 55,701.5 мянган төгрөгийг одоог хүртэл урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна.

Бараа материал:

Тайлант 2019 онд бараа материалын дансанд 403,692.8 мянган төгрөгийн орлого авч 350,438.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,184,002.4 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 4

Бараа материалын үлдэгдэл

/Мянган төгрөгөөр/

#	Үзүүлэлт	Тусгай зориулалтын материал	Бэлэн бүтээгдэхүүн	Бичиг хөргийн материал	Түлш, шатах тослох материал	Аж ахуйн материал	Бусад хангамжийн материал	Дүн
2019 он	Оны эхний үлдэгдэл	1,817,019.8	286,098.7	692.0		21,812.6	5,124.5	2,130,747.6
	Нэмэгдсэн	335,373.1		4,318.4	3,036.0	5,627.8	5,337.5	403,692.8
	Хасагдсан	311,850.4	19,478.5	4,596.4	1,796.0	11,316.7	1,400.0	350,438.1
	Эцсийн үлдэгдэл	1,890,542.4	266,620.2	414.0	1,240.0	16,123.7	9,062.0	2,184,002.4
2020 он	Нэмэгдсэн	351,686.6		4,919.2		866.2	6,378.3	363,850.3
	Хасагдсан	473,847.5	39,018.2	4,601.9	1,240.0	736.5	4,241.6	523,685.8
	Эцсийн үлдэгдэл	1,768,381.5	227,602.0	731.3	-	16,253.4	11,198.7	2,024,166.9
2021 оны 3 улирал	Нэмэгдсэн	6,200.0		2,822.5		60.0	5,442.1	14,524.6
	Хасагдсан			3,127.0		53.9	5,002.2	8,183.0
	Эцсийн үлдэгдэл	1,774,581.5	227,602.0	426.8	-	16,259.5	11,638.6	2,030,508.5

2020 онд 363,850.3 мянган төгрөгийн бараа материал худалдаж авч 523,685.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 2,024,166.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна. Энэ үлдэгдлийн 87 хувь буusu 1,768,381.5 мянган төгрөг нь тусгай зориулалтын материал байгаа ба тус дансанд нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг бүртгэсэн байна. Тус дансанд НМТГ-н ашигладаг үндсэн хөрөнгийн шинжтэй 96,932.7 мянган төгрөгийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэгдсэн нь Няглан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.4 нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө хамаарна заалтад нийцэхгүй байна.

Хүснэгт 5

Үндсэн хөрөнгө рүү шилжүүлэх хөрөнгө

/мянган төгрөгөөр/

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо	Нийт үнэ
1	Access point	686.6	3	2,059.8
2	Lan pro багаж	1,617.1	3	4,851.3
3	Батерей /2019 НХААГ-19/098	616.6	76	46,857.8
4	Батерей хайрцаг/НХААГ-19/098	5,467.8	2	10,935.5
5	Дэлгэц Dell 24" HD	385.0	4	1,540.0
6	Дэлгэц /SmartBord Kapp Pro/	19,822.0	1	19,822.0
7	Дэлгэц 21инч/НХААГ-19/110	397.1	2	794.2
8	Смарт кэйборд НМТГ/20181131	530.0	2	1,060.0
9	Суурин компьютер/НХААГ-19/110	1,606.6	2	3,213.1
10	Тог баригч тэжээлийн хайрцаг/НХААГ-19/098	2,026.0	1	2,026.0
11	Тэжээлийн хайрцаг/НХААГ-19/098	3,773.0	1	3,773.0
Нийт дун				96,932.7

Мөн нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 741,059.8 мянган төгрөгийн ажлуудыг эзэмшиж, ашиглаж байгаа байгууллагад хүлээлгэж өгөөгүй, мөн ашиглах хугацаа дууссан лиценз, суурилуулалтын зардлыг бараа материалын данс бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт 6

Данс бүртгэлээс хасах

/мянган төгрөгөөр/

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо	Нийт үнэ
1	GPS/UB school 2019/авто машин	420.0	1	420.0

2	RFID бугуйвч/UB school 2019/	4.0	1,000	4,000.0
3	Газрын харилцааны төрөлжсөн мэдээллийн сан	310,654.6	1	310,654.6
4	Дундын мэдээллийн санг өргөжүүлэх	21,450.0	2	42,900.0
5	Карт уншигч/UB school 2019/	320.0	40	12,800.0
6	Серверийн лиценз	119,349.5	1	119,349.5
7	Сууринуулалтын зардал	16,835.7	1	16,835.7
8	Улаанбаатар.мн	18,400.0	1	18,400.0
9	Цагдаагийн байгууллагыг нэгдсэн сүлжээнд	215,700.0	1	215,700.0
	Нийт дүн			741,059.8

Иймд дээрхи бараа материалд тусгагдсан хөрөнгийг холбогдох газарт хүлээлгэн өгч данс бүртгэлээс хасах шаардлагатай байна.

Үндсэн хөрөнгө:

НТМГ нь 2019 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 911,218.5 мянган төгрөгийн, урсгал санхүүжилтээр 9,405.0 мянган төгрөгийн нийт 920,623.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. НӨАУГ-н 2019 оны А/06 дугаар тушаалын дагуу ОСНААУГ ОНӨААТҮГ-т 78,100.0 мянган төгрөгийн програм хангамжийг балансаас балансад шилжүүлсэн байна.

Хүснэгт 7

Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Огноо	Үзүүлэлт	Машин тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Бусад үндсэн хөрөнгө	Програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	Дүн
2019	Эхний үлдэгдэл	3,123,420.3	60,234.5	106,003.8	1,332,755.8	5,387,495.1	10,009,909.6
	Нэмэгдсэн	329,930.0	9,405.0	00.0	00.0	581,288.5	920,623.5
	Хасагдсан	00.0	00.0	00.0	78,100.0	00.0	78,100.0
	Эцсийн үлдэгдэл	3,453,350.3	69,639.5	106,003.8	1,254,655.8	5,968,783.6	10,852,433.0
2020	Нэмэгдсэн	242,504.8	414.9	412,088.6	00.0	82,900.6	737,908.9
	Хасагдсан	230,487.6	1,377.0	00.0	270,102.3	528,941.5	1,030,908.4
	Эцсийн үлдэгдэл	3,465,367.4	68,677.4	518,092.4	984,553.5	5,522,742.7	10,559,433.5
2021 оны туравдугаар улирал	Нэмэгдсэн	26,004.7	00.0	00.0	00.0	00.0	26,004.7
	Хасагдсан						00.0
	Эцсийн үлдэгдэл	3,491,372.1	68,677.4	518,092.4	984,553.5	5,522,742.7	10,585,438.2
	Хуримтлагдсан элэгдэл	2,727,827.9	47,815.1	131,135.8	793,178.1	4,469,071.8	8,169,028.6
	Үлдэгдэл өртөг	763,544.3	20,862.3	386,956.6	191,375.4	1,053,670.9	2,416,409.6

Тус байгууллага 2020 онд гэмт хөргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хөрөнгө, нийслэлийн хөрөнгө оруулалт болон урсгал санхүүжилтээр нийт 737,907.9 мянган төгрөгийн камержуулах ажил хийгдэн данс бүртгэлд тусгасан байна.

НӨАУГ-н 2020 оны 04 дүгээр сарын А/111 дугаар тушаалын дагуу 1,030,908.4 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

Өглөг:

Тус газарт 2017 онд ажилчидтай холбоотой өглөг 21,2 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг дансанд Гүрүтаг ХХК-д 2,964.5 мянган төгрөгийн өглөгийг тухайн үед ажил хариуцаж байсан нягтлан бодогч нь тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг үүсгэсэн байна.

Мөн байгууллагад төлөх өглөг дансанд барьцаа дансны 2019 онд 14 ажлын 181,354.2 мянган төгрөг, 2020 онд 21 ажлын 245,489.0 мянган төгрөг, 2021 оны туравдугаар улирлын байдлаар 16 ажлын 134,576.2 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 8

Өглөг

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019	2020	2021 оны гуравдугаар улирал
1	Ажилчидтай холбогдсон өглөг	21.2	21.2	21.2
2	Байгууллагад төлөх өглөг	184,426.5	248,561.3	140,046.7
	Нийт дүн	184,447.7	248,582.5	140,067.9

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн мэдээллийн санг үүсгэж эцэг эхчүүдийг мэдээллээр хангах гар утасны аплликэйшн хөгжүүлэх бүртгэлийн системийн нэмэлт хөгжүүлэлт хийж нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн НМТГ-18/011 дугаар гэрээг байгуулан ажилласан хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгагдсан барьцаа чөлөөлөх хугацаа дууссан, гүйцэтгэгч байгууллагад ажил дүгнэж олгоогүй 7,785.1 мянган төгрөг байна.

Нэмэлт санхүүжилт:

НМТГ нь 2019 онд нэмэлт санхүүжилтээр: 2018 оны ажлыг дүгнэж урамшуулалд олгосон 7,200.0 мянган төгрөг, Сургуулийн автобус төсөл 46,400.0 мянган төгрөг нийт 53,600.0 мянган төгрөгийг орс ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 9

Нэмэлт санхүүжилт

/мянган төгрөгөөр/

Захирамж	Зориулалт	Мөнгөн дүн
2019		
A/52	2018 ажил дүгнэх урамшуулал	7,200.0
A/1298	Сургуулийн автобус төсөл	46,400.0
Дүн		53,600.0
2020		
	Нийслэлийн Сонгуулийн хороо	49,234.0
НИТХ-ын A/51	Нийслэлийн Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан дүүрэг болон зуслангийн зам дагуу нутаг дэвсгэрт камержуулах ажил	364,259.4
НОК-ын A/747	Урамшуулал	1,000.0
A/1005	Нэг хот-Нэг стандарт болзолт уралдааны шагнал	2,700.0
A/1007	Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн жилийн цахим бүртгэлийг зохион байгуулах	11,585.0
A/1321	Урамшуулал	1,680.0
Дүн		430,458.4
2021 оны гуравдугаар улирал		
A/74	Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн smartcar системээр дамжуулан хөл.хорионы үед замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд тусгай зөвшөөрөл олгох модульд нэмэлт хөгжүүлэлт хийх	9,500.0
	"Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоогоор зорчих иргэдийн цахим бүртгэл, хяналтын систем хөгжүүлж, qr.ulaaanbaatar.mn системд бусад нэмэлт хөгжүүлэлт	9,500.0
	Нийслэлийн хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын бүртгэлийн систем, дашборд, тайлангийн модул хөгжүүлэх дундын мэдээллийн санд аri сервисээр холбох	18,700.0
A/88	Нэг хаалга-Нэг шинжилгээ	89,403.0
Дүн		127,103.9

НИТХ-ийн 2020 оны A/51 дүгээр захирамжаар Нийслэлийн Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан дүүрэг болон зуслангийн зам дагуу нутаг дэвсгэрт камержуулах ажилд 364,259.4 мянган төгрөг, Нийслэлийн сонгуулийн хороонос камержуулалтад 49,234.0 мянган төгрөг, НЗД-н A/1005, НОК-н A/747 дугаар захирамжаар НМТГ-т 3,700.0 мянган

төгрөгийн урамшуулал, Нийслэлийн сургуулийн өмнөх цэцэрлэгийн цахим бүртгэл хийхэд 11,565.0 мянган төгрөг нийт 430,458.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд Нэг хаалга- Нэг шинжилгээ, тээврийн хэрэгслийн тусгай зөвшөөрөл олгох модульд нэмэлт хөгжүүлэлт хийх, qr.ulaaanbaatar.mn системд бусад нэмэлт хөгжүүлэлт хийх, дундын мэдээллийн санд хөгжүүлэлт хийх нийт 127,103.9 мянган төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

НЗД-н 2019 оны A/1298 дугаар захирамжийн дагуу UB school сургуулийн автобусны GPS хяналт, картын системийн ашиглалт үйлчилгээний гэрээг Би Ти Жи Ти ХХК-тай байгуулан Автобусны GPS төхөөрөмж 40 ширхэг, Карт уншигч 80 ширхэг, RFID бугуйвч 1000 ширхгийг нийлүүлэн суурилуулах гэрээг байгуулан ажилласан ба тус хийгдсэн ажлын үр дүнг гараагүй хүгээлгэж өгсөн сургуулийн анхан шатны баримтын бүрдүүлэлт энэ онд хийгдэж байгаа нь 1-яглан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

Төсвийн гүйцэтгэл:

НМТГ нь 2019 онд урсгал зардалд 1,102,772.4 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,051,704.6 мянган төгрөгийг зарцуулж, 50,367.7 мянган төгрөгийг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 10

Төсвийн зарцуулалт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019		2020		2021 оны гуравдугаар улирал	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,102,772.4	1,051,704.6	1,221,403.4	1,179,342.6	940,731.1	629,729.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,323.4	291,649.2	440,609.7	405,081.3	338,369.7	258,841.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтэл	42,165.6	38,104.8	59,482.3	52,300.5	45,680.1	35,860.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	3,847.2	3,847.2	2,885.4	2,885.4
Байрны түрээс	-	-	3,847.2	3,847.2	2,885.4	2,885.4
Хангамж, бараа материалын зардал	17,920.0	16,694.7	25,216.4	26,216.4	20,069.7	9,244.7
Бичиг хэрэг	4,000.0	4,318.4	4,150.0	4,150.0	1,952.5	2,398.5
Тээвэр, шатахуун	5,280.0	5,755.1	8,066.4	8,066.4	5,730.0	5,482.3
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	8,640.0	6,621.2	13,000.0	14,000.0	12,387.2	1,363.9
Эд хогшил, урсгал засварын зардал	9,405.0	9,405.0	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	689,958.4	689,851.0	686,247.8	686,234.8	528,046.2	318,346.5
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,706.0	4,647.6	4,500.0	4,487.0	6,046.2	5,088.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	685,252.4	685,203.4	681,747.8	681,747.8	522,000.0	313,258.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000.0	3,000.0	3,000.0	2,662.5	3,430.0	2,312.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0	2,250.0	2,238.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0	2,250.0	2,238.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,102,772.4	1,051,704.6	1,221,403.4	1,179,342.6	940,731.1	940,116.1

Мөн 2020 онд урсгал зардалд 1,221,403.4 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсанаас 1,180,233.3 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,179,342.6 мянган төгрөгийг зарцуулж, 890.7 мянган төгрөгийг хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

НМТГ-н даргын 2020 оны 12 дугаар сарын 21-ны А/67 дугаар тушаалаар тус байгууллагын дөрөвдүгээр улирлын үнэлгээгээр “хангалттай” үнэлэгдсэн 23 албан хаагчдад тус бүр 1,000.0 мянган төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 11

Мэдээллийн технологийн үйлчилгээний зардал

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019	2020	2021 оны туравдугаар улирал	Тайлбар
1	Сувагчлалын төлбөр, шонгийн түрээс	91,071.0	100,415.0	94,232.1	МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СУЛЖЭЭ
2	Шилэн кабельн үйлчилгээний	60,480.0	50,400.0	45,360.0	ЖИМОБАЙЛ НЭТ ХХК
3	Интернетийн төлбөр	43,626.0	44,666.0	34,056.0	Скайнэтворкс /хороодын интернет/
4	Шилэн кабельн засвар үйлчилгээ	164,380.0	171,840.0	26,750.0	Ньютехнологи дөвөлопмент, /Би Жи Жи Сервис 2021/
5	Агаарын шугамын шонгийн түрээс	9,000.0	9,000.0	6,750.0	Голден Апдейт
6	Вирус, санхүүгийн программ, Домэйн нэр сунгалт	2,192.0	1,917.0	1,704.1	
7	Сургалт			560.0	
8	151510 дугаар, мессежний төлбөр	1,750.0	2,000.0		Юнител ХХК, Жи мобайл ХХК, Мобиком корпораци ХХК
9	Шугамын түрээс	12,000.0	10,000.0		МЗХНН УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ
10	Бараа материал		1,815.0	5,400.0	
11	Бусад	3,668.0	4,655.0		
12	Гэрээт ажлын төлбөр	295,068.0	285,041.0	98,445.8	
Нийт		683,236.0	681,748.0	313,258.0	

НМТГ нь 2019, 2020 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд: Лицензийн төлбөрийг Винит ХХК-д гэрээгээр 83,300.5 мянган төгрөг, 2020 онд 92,316.0 мянган төгрөгийн үнэ бүхий лицензийг шууд худалдан авалт хийсэн, Нийслэлийн Дата төвд 2019 тоног төхөөрөмж засвар хийхэд 32,180.0 мянган төгрөг, нутгийн захиргааны байгууллагуудын эвдрэлтэй тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай 28,720.0 мянган төгрөг, 2019 онд шилэн кабельн засвар үйлчилгээ арчлалт хамгаалалт Ньютехнологи дөвөлопмент ХХК-тай ННСАҮГ/20190118 тоот гэрээ байгуулсан 2020 онд сонгон шалгаруулалт хийлгүйгээр гэрээг сунган 171,840.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төрийн болон орон үнтийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” 8.5. Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно заалтыг мөрдөөгүй байна.

Хөрөнгө оруулалт:

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар НЗД-н 2019 оны А/507 дугаар захирамжаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санг өрөгжүүлэхээр 1,000,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил эрх шилжих ирсэн бай гүйцэтглээр 981,550.7 мянган төгрөгийн ажил хийгдсэн байна. /ХАВСРАЛТ 1/

2020 онд Нийслэлийн төсвийн хөрнгө оруулалатаар 447,771.5 мянган төгрөгийн камеруулалтын ажил хийгдсэн байна. Үүнд: ХУД-н 12, 14, 16-р хороонд хийгдсэн ΘЭМТ-д Глобал телеком ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл 2,484.2 мянган төгрөг, БЗД-н 9, 17, 24-р хороо Түлэнхий хясаа ХХК 1,976.1 мянган төгрөг, ХУД-н 5, 6-р хороо камержуулалтыг Ньютерра вокс ХХК 8,948.4 мянган төгрөгийг ажил нь дуусаагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг барьцаа дансанд шилжүүлсэн авч үлдсэн байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөлд барьцаа хөрөнгө нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Чанарын баталгаат хугацаа 1 жил байна гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 13 Ажлын гүйцэтгэлийн үлдэгдэлийг барьцаа дансанд төвлөрүүлсэн /мянган төгрөгөөр/

№	Хийгдэх ажил	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Барьцаа 5%	Барьцаа дансанд шилжүүлсэн	Зөрүү
1	ХУД-н 12,14,16-дугаар хороо ΘЭМТ -н камержуулалт /Глобал телеком ХХК, /	22,486.6	18,878.0	1,124.3	3,608.6	2,484.2
2	БЗД-н 9, 17,24-р хорооны камержуулалт /Түлэнхий хясаа ХХК/	35,640.9	31,882.8	1,782.0	3,758.2	1,976.13
3	ХУД-н 5,6-р хороо камержуулалт / Ньютерра вокс ХХК/	91,463.6	77,176.9	4,573.2	13,522.6	8,949.44
	Нийт	149,591.1	127,937.6	7,479.6	20,889.4	13,409.8

HTXO-аар хийгдсэн хороо, цэцэрлэг, ΘЭМТ-д хийгдсэн камержуулалтын ажлыг гүйцэтгэл гэрээнд тусгагдсан хугацаанд хүлээлгэж өгөөгүй, байхад алданги тооцоогүй байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөлд алданги ногдуулах хэмжээ: Гүйцэтгэгчид алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс 0.5% байна. Нийт алданги хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна гэж заасныг зөрчсөн байна.

Хүснэгт 14 Гүйцэтгэлийн алданги

/мянган төгрөгөөр/

№	Хийгдсэн ажил	Төсөвт өртөг	Санхүүжих	Гэрээний хугацаа	Гүйцэтгэл гаргасан хугацаа	Зөрүү хоног	Мөнгөн дүн	Гүйцэтгэгч
1	73-р цэцэрлэгийн камержуулалт	18,801.8	18,029.0	2020.04.23-2020.06.25	2020.08.07	42	1,880.1	Жи Ти Кэй Эс ХХК
2	141-р цэцэрлэгийн камержуулалт	25,418.4	25,012.6	2020.06.23-2020.08.25	2020.09.10	15	1,906.4	Спэйшлтим ап ХХК
3	БГД-н 16-р хороо 6-10 гудамжны хяналтын камер	89,709.1	86,697.8	2020.05.29-2020.07.29	2020.10.14	75	8,970.9	Төгс хурц консалтинг
4	БЗД-н 9, 17,24-р хороо -н 5,6-р хороо камержуулалт	37,581.8	35,640.9	2020.06.17-2020.09.01	2020.12.07	95	3,758.1	Түлэнхийхясаа
5	ХУД-н 12, 14, 16-р хороо ΘЭМТ -н 5,6-р хороо камержуулалт	23,449.7	22,486.6	2020.07.30-2020.09.30	2020.10.20	20	2,345.0	Глобалтелеком ХХК
	Нийт дүн	194,960.8	187,867.0				18,860.4	

Дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн талаар:

- 2019 оны A/241 дүгээр захирамжаар тус газрын бүтцийг 3 нэгжтэй, 31 хүртэл, үүнээс орлогч даргатай байхаар баталсан. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай 4 дүгээр тогтоолын 6.2. “хуульд өөрөөр зөагаагүй бол Засгийн газрын агентлаг нь 100-гаас дээш ажилтантай бол дэд ծарга (орлогч дарга) 1-тэй, 100-гаас цөөн ажилтантай бсл дэд буюу орлогч даргагүй байх чиглэл баримтлах” заалттай нийцэхгүй байна.

2. НМТГ нь дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна. Энэ нь ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах хэрэгжилтийг хангах журам”-тай нийцэхгүй байна.
3. Газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/33 дугаар тушаалаар Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг тус хэлтсийн Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Г.Энхзулын албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлэн 40 хувийн нэмэгдэлд 1,489.2 мянган төгрөгийг, 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар Систем хөгжүүлэлтийн хэлтийн Системийн мэргэжилтний албан үүргийг тус хэлтсийн Систем загварчлал хариуцсан мэргэжилтэн Д.Пүрэвдоржийн албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлэн албан тушаалын цалингийн 30 хувийн нэмэгдэлд 983.3 мянган төгрөгийг тус тус илүү олгосон нь МУЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулалт олгох журмын “2.2. түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.” заалттай нийцэхгүй байна.
4. Газрын даргын 2020 оны Б/30 дугаар тушаалаар Систем хөгжүүлэлтийн хэлтсийн системийн оператор Б.Жавзансүрэнд Сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2020 оны гурав, дөрөвдүгээр улирлын урамшуулалт 1,277.2 мянган төгрөгийг олгосон нь МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тэгтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулалт олгох журам”-ын 2.7. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалт олгохгүй заалтыг хэрэгжүүлээгүй байна.
5. Тухайн үед ажил хариуцаж байсан нягтлан бодогчийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотойгоор авлагын дансанд 748.8 мянган төгрөг, Өглөгийн дансанд 3,093.4 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээр бүртгэсэн, урьдчилж төлсөн зардалд 55,701.5 мянган төгрөгийг бүртгэсэн боловч НББ-н зохих бичилтийг хийгээгүйгээс одоог хүртэл үлдэгдлээр тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үргийг хүлээнэ: ...20.2.5 ; дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулэх; 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, өэлтгэннийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; заалтыг зөрчсөн.
6. Тусгай зориулалтын материал дансанд 2015-2019 онд хийгдсэн холбогдох газарт нь хүлээлгэж өгөөгүй нийт 741,059.8 мянган төгрөгийн ХО-н ажил бүртгэлтэй байна.
7. НМТГ-н даргын 2020 оны 12 дугаар сарын 21-ны А/67 дугаар тушаалаар тус байгууллагын дөрөвдүгээр улирлын үнэлгээгээр Хангалттай үнэлэгдсэн 23 албан хаагчдад тус бүр 1,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь ЗГ-н 2019 оны 5 дугаар тогтоол төрийн албан хаагчид мөнгөн урамшуулалт олгох тухай журмын 2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна заалттай нийцэхгүй байна.
8. НМТГ нь 2019 онд Лицензийн төлбөрийг Винит ХХК-д 83,300.5 мянган төгрөг, 2020 онд 92,316.0 мянган төгрөгийг, Нийслэлийн Дата төвд 2019 онд тонг төхөөрөмж засвар хийхэд 32,180.0 мянган төгрөг, нутгийн захиргааны байгууллагуудын эвдрэлтэй тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай 28,720.0 мянган төгрөг, нийт 60,900.0 мянган төгрөгийг тус тус сонгон шалгаруулалт хийгдүүгээр шууд гэрээ байгуулан шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 ”Энэ хуулийн 8.1.1-д

заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” 8.5. Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд Багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно заалтыг мөрдөөгүй байна.

9. 2019 онд шилэн кабелын засвар үйлчилгээ арчлалт хамгаалалт хийх Ньютехнологи девелопмент ХХК-тай ННСАҮГ/20190118 тоот гэрээ байгуулан 164,380.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, 2020 онд сонгон шалгаруулалт хийгээгүй, гэрээ байгуулаагүйгээр тус компанийд 171,840.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч ажлын гүйцэтгэлийн тайлан хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланда тусгахыг хориглоно заалтыг мөрдөөгүй байна.
10. 2020 онд Глобал телеком ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл 2,484.2 мянган төгрөг, Түлэнхий хясаа ХХК 1,976.1 мянган төгрөг, Ньютерра вокс ХХК 4,649.5 мянган төгрөгийг ажил нь дуусаагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг барьцаа дансанд шилжүүлсэн авч үлдсэн байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөлд барьцаа хөрөнгө нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Чанарын баталгаат хугацаа 1 жил байна гэж заасантай нийцэхгүй байна.
11. Түлхүүр гардуулах нөхцөлтэй камержуулалтыг ХУД-н 5, 6-р хороонд Ньютерра вокс ХХК-аар гүйцэтгүүлсэн. Гэвч тус ажлын зураг тараагүй байхад ажил дуусаж зургийн үнэ 4,223.4 мянган төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн нь Гэрээний тусгай нөхцөлд барьцаа хөрөнгө нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Чанарын баталгаат хугацаа 1 жил байна гэж заасантай нийцэхгүй байна.
12. НМТГ-ны Инносолюшн ХХК-тай гэрээ байгуулж 2020 онд НМТГ/Н20200702 дугаартай Улаанбаатар хотын гудамж талбайд RFID систем нэвтрүүлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажлын 599,787.1 мянган төгрөгийн гэрээ байгуулсан. 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн ажил хүлээж авах ажлын хэсгийн хурлын тэмдэглэлээр тус ажлын гүйцэтгэлийг 80 хувиар тооцож санхүүжилтийг олгох шийдвэр гарсан байхад 100 хувийн санхүүжилт олгон 119,957.4 мянган төгрөг төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; заалттай нийцэхгүй байна
13. Түлхүүр гардуулах нөхцөлтэй камержуулалтыг ХУД-н 5, 6-р хороонд Ньютерра вокс ХХК-аар гүйцэтгүүлсэн ажлын магдлашгүй ажлын зардал 1,859.8 мянган төгрөг байхад гүйцэтгэлээр 2,292.1 мянган төгрөгийг шилжүүлж магадлашгүй ажлын зардалд 432.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.
14. Төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:
 - 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Бигун вэйв ХХК-тай Лого тэмдэг, Брэнд бүүк, Вэв сайт хийж гүйцэтгүүлэхээр 2020/07 дугаар гэрээ байгуулан 9,100.0 мянган төгрөгийг шилжүүлсэн;
 - 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дүрмээр хүлээх үүрэг, чиглэлд нэг бүрчлэн процессын шинжилгээ хийх, Газрын бүтэц зохион

- байгуулалт, ажлын урсгал судалгаа хийх, үйл ажиллагаа явуулах ажлын урсгал шинэчилсэн процессын төсөл бэлтгэх, Газрын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх, байгууллагын бүтэц, чиг үүргийг нарийвчлах, давхардлыг тодорхойлох, Албан хаагчдын ажлын байрны шинжилгээ, чиг үүргийг бизнес процессын дахин загварчлалаар оновчлох, НМТГ-н бүтэц чиг үүргийн шинэчилсэн загварын бий болгох, Процесс загварын нийцлийг хянах аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр Бизнесийн үйл явцын дахин загварчлал НҮТББ-тай гэрээ байгуулан 9,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн;
- 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Нэг тархи нэг систем төслийн нөхцөл байдлын судалгаа, төслийн модуль судалгаа шинжилгээ хийн тодорхойлох, төслийн шийдэл боловсруулах, хэрэгжүүлэх боломжтой шийдэл боловсруулах, тайлан боловсруулж хүлээлгэж өгөхөөр 2020-05 дугаар гэрээ байгуулан анхан шатны баримтгүйгээр Монголын блокчэйн технологи ба криптоюалютын холбоо ТББ ХХК-д 6,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Мөн тус компаниар Хаскелл програмчлалын хэлний блокчэйн, смарт контракт хөгжүүлэгчийн сургалт зохион байгуулахаар 6,000.0 мянган төгрөгийг гэрээгүй, үндэслэлгүйгээр тус тус шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалттай нийцэхгүй байна.
15. Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хүүхдийн мэдээллийн санг үүсгэж эцэг эхчүүдийг мэдээллээр хангах гар утасны аппдикэйшн хөгжүүлэх бүртгэлийн системийн нэмэлт хөгжүүлэлт хийж нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн НМТГ-18/011 дугаар гэрээг Смарт ложик ХХК-тай байгуулан ажилласан. Тус 2018 оны хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгагдсан барьцаа чөлөөлөх хугацаа дууссан, гүйцэтгэгч байгууллагад ажил дүгнэж олгоогүй 7,785.1 мянган төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухай шатны төсвийн өрөнхий орлогын дансанд татан төвлөрүүлнэ" заалттай нийцэхгүй байна.
16. НТХО-аар хийгдсэн хороо, цэцэрлэг, ӨЭМТ-д хийгдсэн камержуулалтын ажлыг гүйцэтгэл гэрээнд тусгагдсан хугацаанд хүлээлгэж өгөөгүй, байхад алданги тооцоогүй 18,860.4 мянган төгрөг байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөлд алданги ногдуулах хэмжээ: Гүйцэтгэгчид алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс 0.5% байна. Нийт алданги хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна гэж заасныг зөрчсөн байна.

ДҮГНЭЛТ

Нийслэлийн Мэдээллийн технологийн газар нь дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажиллаж, удирдлага, санхүүгийн ажилтнууд нь 2019, 2020, 2021 оны гуравдугаар улиралд санхүүгийн байдал, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, эрх зүйн актын дагуу тайлагнасан байна.

НДАГ-аас НМТГ-ын 2019 он, 2020 он, 2021 оны гуравдугаар улирлын үйл ажиллагаанд хийсэн аудитаар илэрсэн асуудлуудад үндэслэн илэрсэн асуудлууд болон

нийт 1,618,818.9 мянган төгрөгийн зөрчил 37,301.2 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн акт, 9,500.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1,581,017.5 мянган төгрөгийн зөвлөмжийг цаашид давтан гаргахгүй зөвлөмж хүргүүлэн, удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдэж байна.

Цаашид анхаарч ажиллах талаар:

- ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх
- НББ-н тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдах авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах,
- Өглөг, урьдчилж төлсөн зардалыг холбогдох дансанд залруулах бичилтийг хийх
- Авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах
- Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлийн хувиар нь санхүүжүүлэх


ТАНИЛЦСАН:


НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  Б.ЖАВЗАН

ХЯНАСАН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Ч.ГУРБАЗАР

БЭЛТГЭСЭН:

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ
ДОТООД АУДИТОР  Д.НАНСАЛМАА

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДОТООД АУДИТОР  Г.ХУЛАН

ТАНИЛЦАЖ, ЗӨВШЕӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



О.ЧИНЗОРИГ
Б.БАЙГАЛМАА